

**Овгийн тамганы танин мэдэхүйн конструкци,
тиг хэмжээг шинжих нь
(Археологийн олдворын жишээн дээр)**

Гомбожавын Лувсандандар

Олон улсын Улаанбаатар их сургуулийн Инженер Дизайн Технологийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

✉ luvsandandar.g@ulaanbaatar.edu.mn

Хураангуй: Археологийн олдворуудад суурилан овгийн тамганы танин мэдэхүйн конструкци, тэдгээрийн дүрслэл хэлбэр, тиг хэмжээс, харьцаа, гоо зүйн хэм хэмжээний үндсийг судлан, график үйлдлээр хэрхэн гүйцэтгэхийг танилцуулж байна. Овгийн тамганы гадаад хэлбэр, дотоод бэлгэдлийн систем нь нүүдэлчдийн сэтгэлгээ, танин мэдэхүйн өвийн илэрхийлэл тул язгуур дүрсний үүсэл, хөгжлийн зураглалыг схемчлэн харуулсан.

Энэхүү судалгаа нь овгийн тамганы утга агуулга, бэлгэдэл, хувирлын тогтолцоог ойлгож, соёлын өвөөс суралцах, график дизайн болон бүтээлч үйлдвэрлэлийн сургалт, судалгаанд ашиглах боломжийг олгож байна. Иймд энэ чиглэлийн судалгаа нь ирээдүйн дизайнер, судлаач, сонирхогчдод зориулсан боловсролын чухал эх сурвалж болно.

Түлхүүр үгс: *конструктив, харьцаа, гоо сайхан, төгс төгөлдөр*

**Cognitive construction and proportional analysis of Tribal tamgas
(Based on Archaeological Evidence)**

Luvsandandar Gombojav

School of Engineering, Design and Technology,
International University of Ulaanbaatar, Ulaanbaatar, Mongolia

✉ luvsandandar.g@ulaanbaatar.edu.mn

Abstract: This study explores the cognitive construction of tribal seals based on archaeological findings, examining their graphic forms, proportional dimensions, ratios, and aesthetic principles. It also presents a methodology for executing these designs through graphic techniques, highlighting how these elements can be reconstructed and interpreted in a modern context.

The external form and internal symbolic system of tribal seals reflect the nomadic mindset and cognitive heritage. The origins and development of the primary symbols are illustrated through a schematic representatio. This study provides an understanding of

the meaning, symbolism, and transformation system of tribal seals, offering opportunities to learn from cultural heritage and apply this knowledge in graphic design, creative industries education, and research. Therefore, research in this field can serve as an important educational resource for future designers, researchers, and enthusiasts.

Keywords: *constructive, proportion, aesthetics, perfection*

Оршил

Овгийн тамганы график шийдэлд суурилсан сургалт, судалгаа, дизайны бүтээл (лого тэмдэгт гэх мэт) туурвидаг багш, суралцагч, сонирхогч, уран бүтээлчдийн өмнө тэдгээрийн танин мэдэхүйн конструкци, тиг хэмжээ, арга зүйн тодорхойгүй байдал тулгамдсан асуудал болдог бөгөөд түүнийг шинжлэх ухааны үндэслэлтэй гоо сайхны өндөр түвшинд шийдэх, түгээн дэлгэрүүлэх хүрээнд уг судалгааг сонгосон болно. XX зууны дөч, тавиад оны үеэс монгол, оросын түүхч, археологичид Монгол орны нутагт байгаа палеолит, мезолит, неолит болон хүрлийн, төмрийн үеийн олон чухал үнэт дурсгалууд, хадны зургийн шинэ шинэ олдворыг нээн илрүүлсэн онцгой үе бөгөөд тэдгээр нь тамга судлалын судалгаа шинжилгээний эхлэл болсон байна.

Овгийн тамга нь овог удмын гарал үүсэл, түүх, утга соёл, бэлгэдэл, дүрслэлийн сакраль шинж, угсаатны зүй, мал аж ахуйн хууль цаазын ач холбогдол талаас дараах байдлаар судлагджээ. Орос эрдэмтэн В.В.Радловымь Хануй гол, Орхон голын сав нутгийн хад чулуун дээр сийлж бүтээсэн тамга тэмдэг, ан амьтдын зургийг байршлын газрын зургийн хамт нийтэлсэн нь (Радловымь 1893, 12-34) монголын хадны зургийн анхны судалгаа байв.

Академич Х.Пэрлээ монгол овгийн тамганы хэлбэр дүрс, хэв маяг өвөг монгол, алтай язгуур хэлтний эртний бичиг үсгийн үүсэл гаралтай, тэр дундаа руни бичигтэй холбогдож болохыг олонтоо судлан шинжилж долоон анги (Пэрлээ 1976, 71), Д.Чойсамба мал аж ахуйн хууль эх зүйн ач холбогдол, малчдад танин мэдэхүйн зөвлөмж болгож 24 төрөлд (Чойсамба 1974, 42-69) хуваасныг А.Доржготов, Ц.Сонгино нар хууль эрх зүйн хүрээнд эд мөрийн баримтын нэр томъёоны зурагт тольд хэрэглэсэн (Доржготов, Сонгино 1998, 70-83) бол, С.Жамбалдорж адууны тамгыг хэрэглэх, хэмжээний талаар тайлбар тольд (Жамбалдорж 1996, 145) тэмдэглэжээ.

Эрдэмтэн Ж.Саруулбуян, А.Даваасамбуу нар адуун соёлын үнэт өв, уламжлалын хүрээнд өнөөгийн судлагдсан хэмжээнд нягталж, тамганы дүрслэлийг 15 ангид хувааж, 113 үндсэн тамганы нэрээр төрөлжүүлж зүйлчилсэн (Саруулбуян, Даваасамбуу 2008, 19). С.Дулам тамганы дүрслэлийг утга соёлын хүрээнд бэлгэдэл зүйн талаас нь 18 бүлэгт (Дулам 2011, 19-121), П.Гантуяа адууны тамгыг цахим хэлбэрт таниулах арга боловсруулах агуулгын хүрээнд 6 бүлэгт (Гантуяа 2019, 79), Ш.Довдон криминалистикийн талаас малын тамгыг 18 төрөлд (Довдон 2010, 65-77) ангилсан бол, Ц.Баттулга тамгатыг юунд тэмдэг дүрсээр хэрэглэж байгаагаар нь хөшөөний тамга, хад чулууны тамга, эд өлөг дээрх тамга, малын тамга гэж үндсэн дөрвөн зүйлд хуваан үзэж болох юм (тарианы тамга) (Баттулга 2005, 213) хэмээн ангилсан байна. Өвөр монголын судлаач Д.Манлай, Боржигин Б.Ванчиг

(2002) нар дүрс, бэлгэдэл нэршилээр нь ерөнхийлөн 4 бүлэгт, Галиндара (2001) нүүдлийн мал аж ахуйн уламжлалт хэрэглээ, соёлын хүрээнд 5 төрөлд ангилан судалжээ. Эрдэмтэн Б.Нямаа Монголын эзэнт гүрний зоосон мөнгө дээрх хаадын овгийн тамгыг тусгайлан судалж, хаадын овгийн удам угсааны тамганы схемийг (Нямаа 2005, 83) боловсруулжээ. М.Мөнгөнцэцэг (2023) тамганы дүрсээс монгол бүжгийн хөдөлгөөн, нэршлийн гаргалгаа гаргаж, 4 төрөлд ангилсан (Мөнгөнцэцэг 2023, 62) байдаг.

Овгийн тамга, хээ угалз, барааны тэмдэгтийн язгуур дүрсүүд тухайн төрлүүдийн ялгагдах болон нэгдмэл шинжийг хадгалж байдгийн хувьд нэг гарал үүсэлтэй учир Ц.Ядамжав хээ угалзыг системчилж 5 бүлэгт (Ядамжав 2009, 9) ангилсан байдаг бол, Д.Энхдаваа амьтны хээн аймаг, ертөнцийн хээн аймаг, бэлгэдлийн хээн аймаг (Энхдаваа 2018, 110-116) хэмээжээ. Дизайны бүтээлүүдийн сайхан байдал нь тэдгээрийн өнгө, фон, гоёл чимэглэл, урласан арга, чадвараар илрэхийн зэрэгцээ урласан зүйлийн ерөнхий дүрс хэлбэр, бүрдэл хэсгүүдийн харилцан шүтэлцээтэй ихээхэн холбоотой.

Эрт үеэс эхлээд биднийг хүртэлх урлаачдын мод, чулуу, шил, шавар, металл зэрэг янз бүрийн материалаар урласан бүтээлүүдийн дүрс хэлбэр нь нэг талаасаа урлаачийн харьцааны мэдрэмжийн илрэл, нөгөө талаасаа тиг хэмжээний мэдрэмжээр гүйцэтгэсэн зохист шийдэл байдаг. График үйлдлээр тиг хэмжээний аргаар гүйцэтгэж байгаа аливаа зүйлийн харьцаа (пропорц) нь тамга тэмдэг, лого тэмдэгт, аяга, таваг, сав суулга, хувцас хэрэглэл, тавилга, төхөөрөмж, хөдөлмөрийн багаж зэвсэг, техник хэрэгсэл зэрэг янз бүрийн зүйлс болон урлагийн бүтээлийн үндсэн зориулалт, дүрс хэлбэртэй холбоотойгоор дүрсийн гоо сайхны нь анхдагч хүчин зүйл болж иржээ. Эртний Грек, Египет, Римд харьцаа, гармоник харьцааг ойлгон хэрэглэж байсныг судлаачид тогтоож тэмдэглэсээр байна (Төмөрбат 2004, 40).

“Овгийн тамга тэмдгүүд бол тухайн овог аймгийн эзэмшил газар, нүүдэл суудлыг гэрчлэн харуулах чухал баримт юм. Нөгөө талаар тамга тэмдгүүд нь өөрийн нууцлаг байдлаараа үзсэн харсан хүний сэтгэлийг хөдөлгөн өөртөө татаж байдаг онцгой зүйл юм” (Төрбат, Батсүх, Баярхүү 2012, 143) гэж дүгнэсэн нь тамганы дүрс хэлбэрийн харьцаа, тиг хэмжээ нь хүний харааны мэдрэмжид хүртэгдэж, гоо сайхны мэдрэмжийг өдөөж байгаагийн илрэл болно. Энэхүү судалгаагаар овгийн тамганы танин мэдэхүйн конструкцийг боловсруулах, ширээт онги тамганы дүрс хэлбэрийг тиг хэмжээний аргаар гоо сайхны төгс төгөлдөр төлөв байдлыг шинжих, график үйлдлээр бүтээх шийдлийг олохыг зорив.

Овгийн тамганы дүрс үүсгэх аргуудыг эрдэмтэн Х.Пэрлээгийн тэмдэглэснээр “өрхийн малын шинэ тамга дүрсийг үүсгэхдээ - хуучин их өрхийн тамганы дүрс дээр шинэ зураас нэмэх, - хуучин нэг тамганы дүрсийг хоёр, гурав давтан дүрслэх, - хуучин хоёр тамгыг нэгтгэх, - нэгэн тамгыг малын зөв буруу талд давтан дарах, - хуучин тамганы дүрсэнд номын үсэг, тооны үсэг нэмэх зэргээр ...малын толгой тийш буюу дээш доош, дөрвөн зовхист хандуулан (эргүүлэн) дарж, ялгаруулах ёс байсан” (Пэрлээ 1975, 50) нь үндсэн тамганаас хувилбар тамганы дүрс, нэршил үүсгэх, хувиргалтын элементийн тоо, байрлал, байршил, хөдөлгөөн, давтамж зэргийг тодорхойлсон байна.


Судалгааны арга зүй

Овгийн тамганы танин мэдэхүйн конструкцийг гаргахдаа (схем, загвар) судлаачдын тамганы ангилал, бүтэц, нэршил, зохист нэмэрлэхүйн хэллэг, хувиргалтын элементийн хэлбэрийг системчлэх, тамганы дүрс бүтээх аргачлалыг баганан хэлбэрээр зэрэгцүүлэн харьцуулах аргыг хэрэглэж, утга санаа, бэлгэдэл, нэршил, түүвэрлэсэн мэдээлэлд анализ, синтезийн аргыг ашиглан боловсруулав. Эх сурвалжаас судалгааны хэрэглэгдэхүүнийг сонгохдоо харьцааны өөрчлөлтгүй, график үйлдлээр хуулбарлан авах зарчим баримтлав. Энэхүү судалгаанд баримтын судалгаа, жишин харьцуулах, овгийн тамганы дүрс хэлбэрийг тиг хэмжээ, харьцааны аргаар судалж, график шийдлийн хувилбар байгуулалтыг тодорхойлов.


Судалгааны үр дүн - 1

Овгийн тамганы нэг дүрс нэг л бодит болон хийсвэр юмнаас үүссэн байдаг тул тэр эх дүрс юу вэ? гэдэгт тулгуурлаж гарал үүслийн ангилал хийх зарчмыг баримталсан болно. “Овгийн тамганы үндэс нь нэг л зурлага дүрсээс үүссэн байдаг, харин тамга нэмэн дам үүсгэхдээ олон янзын цэг, зураас, хээ угалз нэмдэг” (Пэрлээ 1976, 33) байна. “Аливаа дүрс нэг л нүднээс (цэгээс) ...эх дүрсийг тогтооход хоёр үндсэн арга байж болно. Нэгд, бэлэн уламжилсан эх дүрсүүдийг бүртгэн тооцоолох, хоёрт, эх дүрсүүд маань ч гэсэн бүтэц, зохиомжийн хувьд нэгэн уг эхээс үүсмэл байж болох боломжийг харгалзав” (Дулам 2011, 12).

“Дүрсийг уран сайхны хийц маягийн хувьд хэрэгцээ, зорилго, бэлгэдлийн зүгээс бүтээдэг тул хэлбэр бүр өөр өөрийн өвөрмөц онцлогтой байдаг. Судалгаандаа дуурайж хуулбарлах, хувиргаж хэлбэрчих, сэлгэж задлах, нэгтгэн ерөнхийлөх гэсэн үндсэн аргыг авч үзээд” (Гантуяа 2019, 63) тамганы төрлийг дүрс бүтэх аргуудад харьяалуулсан байдаг.




Зураг 1. Овгийн үндсэн тамганы дүрсийн тогтолцоо



Зураг 2. Овгийн хувилбар тамганы дүрсийн тогтолцоо

Ийнхүү судлаачдын бүтээлүүдээс овгийн тамганы үүсэл гарлын ангилал, дүрс бүтэх арга барицыг шүүрдэн авч, гадаад хэлбэр, дотоод агуулгын харилцан шүтэлцээ, чанад санаа бэлгэдэлд тулгуурлан нүүдэлчдийн танин мэдэхүйн

болон уран сайхны сэтгэлгээ, ойлголтын ялгамжтай, нийлэмжтэй байдлыг жишин харьцуулж, овгийн тамганы дүрсийн гарал үүсэл, хувиргалтын элемент, хөгжлийн зураглалыг боловсруулж, нүүдэлчдийн овгийн тамганы танин мэдэхүйн конструкцйг 1-3 схемээр боловсруулав. Энэ нь овгийн тамганы бүтэц тогтолцоо, хувиргалтын элементийн утга санааг ойлгох, урлагийн уламжлалаас суралцах, өгөгдсөн мэдээллийг өөрсдөө нээн илрүүлэх замаар суралцах боломжийг нээн өгч байна.



Зураг 3. Овгийн тамганы нийлмэл дүрсийн үүслийн зураглал

Хүннү нар өмнөх үеэс уламжилж ирсэн сэрээ, дэгрээ, наран, алхан зэрэг тамганаас улбаалан нийлмэл тамгыг үүсгэн хэрэглэж байсан байх магадлалтайг харуулж байна. Ямаан усны хадны зураг дахь нэгэн нийлмэл тамга хүннүгийн морин тэрэгний дэргэд зурагдсан байгаа нь уг зургийг зурсан хүний овгийн тамга ч байж болохыг үгүйсгэх аргагүй билээ (Батболд 2011, 29).

Судалгааны үр дүн - 2

Чулуун зэвсгийн үеэс НТ XIV зуун хүртэлх монгол угсаатны түүхийн дөрвөн өөр үе, цаг хугацаанд хамаарах археологийн олдвороос илэрсэн Рашаан хадны ширээт онги (Пэрлээ 1976, 94), шагайны ширээт онги (Эрдэнэбаатар, Идэрхангай 2015, 139), тоосгоны ширээт онги (Хархорины музей), зоосны ширээт онги (Нямаа 2005, 30) тамгыг тус тус судалгааны эх сурвалжаар сонгон авсан болно.



*Зураг 4. Рашаан хад
Тамгатай хад*



*Зураг 5. Хүннү
Тамгатай шагай*



*Зураг 6. Хархорум
Тамгатай тоосго*



*Зураг 7. Их
Монгол улс
Тамгатай зоос*


Эрдэмтэн судлаач Б.Сумьяабаатар “Ширээт онги” тамганы дүрс хэлбэрийг XIII зууны буюу Чингис хааны үед ч дээдлэгдэж байсан ба зоос, тамгандаа байдаг “ширээт онги” гэдэг тэмдэг ч “Нар, дэлхий, хүн” гурвын нэгдэл, түүний бэлгэдэл юм (Сумьяабаатар 2020, 2259), “онги” гэдэг нь “ван туг” гэсэн утгаар үлджээ гээд “онги” тамга дугариг, босоо, хөндлөн махбодоос бүрдэнэ. Дугариг нь “тэнгэр”, эсвэл “нар”, хөндлөн нь “дэлхий” буюу “этүгэн”, “нар”(=тэнгэр), “дэлхий” хоёрын дунд байгаа босоо зурам нь “хүн”-ийг төлөөлнө (Сумьяабаатар 2020, 2060) хэмээн утгыг тайлсан байдаг.

Тиг хэмжээ харьцаа нь хорвоо ертөнц анх үүссэн цагаас эхлэн байсан боловч хүн төрөлхтөн хэзээ түүнийг нээж ашиглаж эхэлснийг тодорхойлох аргагүй бөгөөд


тиг хэмжээ, харьцааны тухай ойлголт НТӨ III зууны үед зохиогдсон эртний грекийн алдарт математикч Евклидийн “Эхлэл” бүтээлд тусгагдсан байдаг байна.

Тиг хэмжээ, харьцаа нь “Бүхлийг (C) уртад (A) харьцуулсан харьцаа, уртыг (A) богинод (B) харьцуулсан харьцаатай тэнцүү” гэх математик үндэслэлтэй ойлголт бөгөөд Д.Энхдаваа “энэ нь хэмжихүй ухааны харьцааны хувьд бүхэл нь том хэмжээ ба бага хэмжээ тэдгээрийн нийлбэрээс бүрдэх хувьтай” гээд “хээний алтан огтлолын бүтэц, байгуулалтын зураглал” (Энхдаваа 2018, 18-19) гэж тодорхойлсон байдаг.


Дээрх дөрвөн ширээт онги тамганы тиг хэмжээг гадаад хэлбэрийн гоо сайхны байгуулалт болох алтан огтлолын харьцаанд хөврүүлэн авч үзвэл дараах үр дүн илэрч байв.




Зураг 8. Рашаан
хадны тамга



Зураг 9. Шагуйн
тамга



Зураг 10. Тоосгоны
тамга



Зураг 11. Зоосны
тамга

Дээрх дөрвөн тамганы ерөнхий харьцаа $C:A=1.618$ ба бүрдэл хэсгийн харьцаа $A:C=B:A=0.618$ тоон утгаар илэрхийлэгдэж байгаа нь хүн төрөлхтний хөгжлийн явцад цаг хугацаа, газар зүйн байршлаас үл хамааран урлаачдын гоо сайхан, төгс төгөлдөр байдлыг илэрхийлэх тиг хэмжээний мэдрэмж нийтлэг хөгжиж ирснийг нотолж байна.

Нүүдэлчид “Бодит байдлыг бүрдүүлэгч үй түмэн юмсыг нэгэн адил хүмүүний бие ба биесийн хэмжээ харьцааны төгс төгөлдөр байдлыг судлан тогтоож, гоо сайхны хэм хэмжээ болгож иржээ. Монгол Данжуур дахь “Бие зарлиг сэтгэлийн хувь хэмжээ оршвой” зохиолд: “... бие хэдий бөгөөс алд төдий бөгөөд алд хэдий бөгөөс бие төдий болгогдохуй ...” гэжээ” (Сарантуяа 1999, 102).

Хувь хэмжээний үүднээс бурханы дээд хувилгаан дүр хийгээд бодисэтгэлтэн нугуудыг арван нүүрний хэмжээтэй лагшинтан, бурханы эх, охин тэнгэрүүдийг есөн төөний хэмжээтэй лагшинтан, хилэнтэнгүүдийг найман төөний хэмжээтэй лагшинтан, жижиг одой тэргүүтэнг зургаан төөний лагшинтан хэмээн таван хувь хэмжээний дотор багтаадаг бөгөөд энэ нь арвай, хөл, хуруу, нүүр, баг хувь, их хувь (харьцааны нэгж) зэрэг хэмжээсүүдээр босоо, хэвтээ, өнцөг, тойрог зэрэг шугамуудыг ашиглаж, бурхдын лагшин дүрийн зөв харьцаа, төгс гоо сайхныг илтгэн гаргах онолын үүднээс танин барих арга болдог (Пүрэвбат 2016, 22) байна. Өөрөөр хэлбэл, бэлгэ тэмдгийн дүрслэлээр томьёологдон илэрхийлэгддэг сэтгэлгээний урлаг болно (Пүрэвбат 2016, 150).

Судлаач Ж.Төмөрбат “Алтан огтлолын харьцааг хэрэглэх урлаачийн мэдрэмж нь нийт хүн төрөлхтний бүтээн урлах үйл ажиллагаанд нийтлэг байж болно” (Төмөрбат 2004, 43) хэмээн дүгнэсэн байдаг. Дөрвөн өөр цаг хугацаанд бүтээгдсэн

овгийн тамганы тиг хэмжээ нь алтан огтлолын харьцаатай нийцэж байгаа нь анхаарал татаж байгаа бөгөөд тохиолдлын зүйл биш бололтой.

Ширээт онги тамганы тиг хэмжээнд үндэслэн график үйлдлээр бүтээх ширээт онги тамганы хоёр хувилбарын шийдлийг хавсралтаар үзүүлэв.

Хэлэлцүүлэг

Овгийн тамга бол нүүдэлчдийн оюуны өв, соёл, урлагийн үнэт илэрхийлэл юм. Тэдгээр нь зөвхөн нэгэн овгийн тэмдэг төдийгүй тухайн овгийн үзэл санаа, сэтгэлгээ, амьдралын хэв маяг, танин мэдэхүйн тогтолцоог тусган харуулдаг. Иймээс овгийн тамганы танин мэдэхүйн конструкцийг судлах нь зөвхөн дүрслэх урлагийн бус, гүн гүнзгий соёл, урлаг судлалын ач холбогдолтой. Археологийн олдворуудад тулгуурлан овгийн тамганы дүрслэл хэлбэр, тиг хэмжээс, харьцаа, гоо зүйн хэм хэмжээг шинжлэх замаар бид зөвхөн түүхэн мэдээлэл цуглуулах биш, харин ч тухайн ард түмний сэтгэлгээний онцлогийг ойлгох боломжтой болж байна. Овгийн тамган дахь харьцаа, тигийн зохицол нь зөвхөн гоо сайхны төдийгүй мэдээллийн бүтэцтэй, логик дараалалтай, график байгуулалттай байдаг нь судалгааны явцад тодорч байна.

Энэхүү судалгааны үр дүнд язгуур дүрсийн үүсэл, хөгжлийн процессыг схемчлэн үзүүлснээр тамганы гадаад хэлбэр, дотоод бэлгэдлийн тогтолцоог системтэй ойлгох боломж бүрдсэн. Мөн график үйлдлийн аргаар овгийн тамганы бүтцийг сэргээн зохиох арга зүйг боловсруулснаар соёлын өвийг орчин үеийн боловсрол, бүтээлч үйлдвэрлэлд үр өгөөжтэйгөөр ашиглах шинэ гарц нээгдэж байна.

Тухайлбал, овгийн тамганаас урган гарч буй дүрслэлийн хэм хэмжээ, харьцааны зарчим нь график дизайн, лого хөгжүүлэлт, соёл, урлагийн бүтээгдэхүүн бүтээх сургалтын хөтөлбөрт маш үнэ цэнтэй эх сурвалж болж чадна. Ийм судалгаа нь ирээдүйн дизайнер, судлаач, соёл, урлаг судлал сонирхогчдод танин мэдэхүйн ба бүтээлч сэтгэхүйг хослуулсан боловсрол олгоход үнэлж баршгүй хувь нэмэр оруулна.

Иймээс овгийн тамганы танин мэдэхүйн конструкци болон тэдгээрийн тиг хэмжээсийг судлах ажил нь зөвхөн өнгөрснийг сэргээх биш, харин ирээдүйн соёл, урлагийн бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийг чиглүүлэх боловсролын чухал тулгуур суурь болохыг энэхүү хэлэлцүүлгээр онцолж байна.

Дүгнэлт

Овгийн тамганы дүрслэл нь бие, хэл, сэтгэлийн уламжлалт урлах ухаан, уран сайхны сэтгэлгээний урлагийн илэрхийлэл, үр дүн бөгөөд танин мэдэхүйн конструктив онолын үүднээс авч үзвэл бүтэц тогтолцоотой байна. Ширээт онги хэмээх өөр өөр цаг үед хамаарах дөрвөн тамганы ерөнхий харьцаа $C:A=1.618$ ба бүрдэл хэсгийн харьцаа $A:C=B:A=0.618$ тоон утгаар илэрхийлэгдэж байгаа нь хүн төрөлхтний хөгжлийн явцад цаг хугацаа, газар зүйн байршлаас үл хамааран урлаачдын гоо сайхан, төгс төгөлдөр байдлыг илэрхийлэх тиг хэмжээний мэдрэмж нийтлэг хөгжиж ирснийг нотолж байна. Овгийн тамганы дүрс, хэлбэрийн гоо сайхан, төгс төгөлдрийн төлөв байдлыг илэрхийлсэн график шийдлийг дизайн, зураг зүйн бүтээлд хэрэглэх, аливаа дүрслэлийн тиг хэмжээг байгуулах аргыг танин мэдэх, сургалт, судалгаа, уран бүтээлд ашиглах боломжтой.

Ашигласан материалын жагсаал

- Батболд, Н. 2011. “Хүннүгийн хадны зураг.” *Археологийн судлал* XXXI. Fasc. 2: 26-39.
- Баттулга, Ц. 2005. *Монголын руни бичгийн бага дурсгалууд. Тэргүүн дэвтэр*. Улаанбаатар: Эдмон.
- Гантуяа, П. 2019. *Адууны тамганы дүрсийн судалгаа*. Улаанбаатар: Битпресс ХХК.
- Дулам, С. 2011. *Монгол бэлгэдэл зүй III: Дүрсийн бэлгэдэл зүй, дохио зангааны бэлгэдэл зүй*. Улаанбаатар: Битпресс ХХК.
- Довдон, Ш. 2010. *Криминалистик (мал судлал)*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Доржготов, А., Сонгино, Ч. 1998. *Зурагт толь (эд мөрийн баримтын товч нэр томьёо)*. Улаанбаатар: Өнгөт хэвлэл.
- Жамбалдорж, С. 1996. *Морин эрдэнэ*. Улаанбаатар.
- Мөнгөнцэцэг, М 2023. *Хадны зураг, тамганы дүрсээс монгол бүжгийн хөдөлгөөн, нэрилийн гаргалгаа*. Улаанбаатар.
- Манлай, Д. Ванчиг, Д. 2002. *Монголчууд ба морь (Монгол үндэсний морин соёлын дээж бичиг оривой)*. Хөх хот.
- Нямаа, Б. 2005. *Монголын эзэнт гүрний зоосон мөнгө, хаадын овгийн тамга. (XIII-XIV зуун)*. Улаанбаатар.
- Пэрлээ, Х. 1976. *Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр.
- Пүрэвбат, Ганхүү. 2016. “Монголын бурхны шашны урлахуй ухааны тогтолцоо болон хөгжлийн хэтийн төлөв, үнэлэмжийн асуудал.” Ph.D дисс, Улаанбаатар Эрдэм дээд сургууль.
- Радловымъ, В.В. 1893. *Атласъ древности Монголий*. Санктпетербуркъ. <https://elib.rgo.ru/safeview/123456789/51526/1/MjNfQXRsYXMgZHJldm5vgaXpkLiBwbYBwb3JlY2h1bml5dSBJbXAucGRm>.
- Сумьяабаатар, Б. 2020. *Монголын нууц товчоо*. Улаанбаатар: Жиком пресс ХХК.
- Саруулбуян, Ж., Даваасамбуу, А. 2008. *Монгол адууны тамганы ойллого*. Улаанбаатар: Бемби сан ХХК.
- Сарантуяа, Н. 1999. “Урлаг дахь каноны тухай асуудалд.” *Монголын соёл, урлаг судлал*. I.
- Төмөрбат, Ж. 2004. “Монгол, Солонгосын нутгаас олдсон археологийн зарим олдворын харьцаанд хийсэн ажиглалт.” *УБДС-ийн ЭШ-ний бичиг* 01/02: 40-43.
- Төрбат, Ц., Батсүх Д., Баярхүү Н. 2012. “Хүннүгийн археологийн тамганууд люаньди овгийн тамга болох нь.” *Археологи судлал* XXXII, Fasc.9: 136-154.

Чойсамба, Д. 1974. *Малын им тамга хууль цаазын ач холбогдол*. Улаанбаатар.

Эрдэнэбаатар, Д., Идэрхангай, Т., Мижиддорж, Э., Оргилбаяр, С. ба бус. 2015. *Балгасын тал дахь Гол мод-2-ын Хүннүгийн язгууртны бушины судалгаа*. Улаанбаатар.


Энхдаваа, Д. 2018. *Түмэн хээ. боть I*. Улаанбаатар.

Ядамжав, Ц. 2009. *Хээ угалз*. Улаанбаатар. Соёмбо принтинг.

Хархорум музей. 2020. "Тамгатай тоосго. XIII-XIV зуун." Facebook, 29. Nov. 2020.
https://www.facebook.com/photo/?fbid=3532848860096015&set=a.537291782985086&locale=nl_NL

Хавсралт

"Ширээт онги" тамганы график шийдлийг 1-15 алхамаар гүйцэтгэх 1-р хувилбар



"Ширээт онги" тамганы график шийдлийг 1-15 алхамаар гүйцэтгэх 2-р хувилбар

